



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Засаг даргын хөтөлбөр, үйл ажиллагааны зардлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2024/81-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт 2024 он	Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас: 99035990 Цахим хаяг: davaag@audit.gov.mn Аудитын менежер: М.Нарантуяа Утас: 99029193 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn Аудитор: Э.Алтансүх Утас: 91009002 Цахим хаяг: altansukh@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА М.ИДЭРБАТ ТАНАА

᠒᠐᠒᠘.᠐᠗.᠒᠑ № ᠒᠐4  
танай \_\_\_\_\_ - ны№ \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Засаг даргын хөтөлбөр, үйл ажиллагааны зардлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Засаг даргын хөтөлбөр, үйл ажиллагааны зардлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сургалт, зөвлөгөөн зохион байгуулах, ажлын хэсгийн хуралдаан хийх гэх мэт арга хэмжээг зохион байгуулах тохиолдолд тухайн арга хэмжээнд оролцогчид нь албан томилолтой, эсхүл сургалтын үйлчилгээний төлбөр авч байгаа бол байр, хоол, тээврийн хэрэгслийн зардлыг зохион байгуулагч тал хариуцахгүй байх шаардлагатай байна.

### Аудитын гол асуудал

Мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлж буй арга хэмжээний үр дүнгийн шалгуур үзүүлэлт, суурь ба хүрэх түвшин, үр дүнг хэмжих арга, үр дүнг хэзээ тайлагнах, хэрхэн хянах талаар захирамжийн хавсралтад тусгуулж батлуулах, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлж буй арга хэмжээний үр дүн, үр нөлөөг тодорхой болгож, төсвийн үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Төрийн сангаар ажил гүйлгээ хийхийн өмнө тухайн бараа, тоног төхөөрөмж цахим дэлгүүрт байршсан эсэхийг нягталж, цахим дэлгүүрт байршсан барааг авах, байршаагүй тохиолдолд ажил гүйлгээний төлбөрийн хүсэлтэд нотлох баримтыг хавсарган баримтжуулаагүй байна. Мөн тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтын үзүүлэлтээр зах зээлийн үнийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсний үндсэн дээр тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг тодорхойлж, төлөвлөх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР \_\_\_\_\_ Г.ДАВАА



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>333,000,000.00</b>	<b>280,000,000.00</b>
33	<b>АВЛАГА</b>	333,000,000.00	260,000,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	333,000,000.00	260,000,000.00
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	20,000,000.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	-	20,000,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>333,000,000.00</b>	<b>280,000,000.00</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,944,922,191.57</b>	<b>11,239,319,772.83</b>
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	5,944,922,191.57	11,239,319,772.83
422	<b>Урт хугацаат зээл</b>	5,944,922,191.57	11,239,319,772.83
4221	<b>Төгрөг</b>	5,944,922,191.57	11,239,319,772.83
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	5,944,922,191.57	11,239,319,772.83
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>(5,611,922,191.57)</b>	<b>(10,959,319,772.83)</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	(5,611,922,191.57)	(10,959,319,772.83)
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(5,611,922,191.57)	(10,959,319,772.83)
51210	Өмнөх үеийн үр дүн	(5,611,922,191.57)	(5,611,922,191.57)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(5,347,397,581.26)
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>333,000,000.00</b>	<b>280,000,000.00</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,334,055,610.00</b>	<b>9,427,095,200.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>391,000,000.00</b>	-
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	391,000,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	391,000,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	391,000,000.00	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,943,055,610.00</b>	<b>9,427,095,200.00</b>
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	2,943,055,610.00	9,427,095,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,943,055,610.00	9,427,095,200.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,943,055,610.00</b>	<b>9,407,095,200.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,227,577,792.00</b>	<b>8,531,353,062.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,838,500,933.00	7,506,320,312.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	224,049,500.00	917,596,373.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	224,049,500.00	917,596,373.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,614,451,433.00	6,588,723,939.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,614,451,433.00	6,588,723,939.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	330,000,000.00	868,439,400.00
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	-	387,233,800.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	387,233,800.00
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	330,000,000.00	481,205,600.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	330,000,000.00	481,205,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	59,076,859.00	156,593,350.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	59,076,859.00	156,593,350.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,076,859.00	156,593,350.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>715,477,818.00</b>	<b>875,742,138.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	715,477,818.00	875,742,138.00
221001	Их засвар	715,477,818.00	875,742,138.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>391,000,000.00</b>	<b>20,000,000.00</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	3,124,334,525.90	5,367,397,581.26
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	936,953,091.33	-
230001	Эргэж төлөгдөх зээл	2,187,381,434.57	5,367,397,581.26
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(3,124,334,525.90)	(5,367,397,581.26)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(2,733,334,525.90)</b>	<b>(5,347,397,581.26)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,943,055,610.00</b>	<b>9,427,095,200.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,943,055,610.00</b>	<b>9,427,095,200.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	2,943,055,610.00	9,427,095,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,943,055,610.00	9,427,095,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,227,577,792.00</b>	<b>8,551,353,062.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,227,577,792.00</b>	<b>8,551,353,062.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,838,500,933.00</b>	<b>7,526,320,312.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	224,049,500.00	917,596,373.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	224,049,500.00	917,596,373.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,614,451,433.00	6,608,723,939.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,614,451,433.00	6,608,723,939.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>330,000,000.00</b>	<b>868,439,400.00</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	-	387,233,800.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	387,233,800.00
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	330,000,000.00	481,205,600.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	330,000,000.00	481,205,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,076,859.00</b>	<b>156,593,350.00</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	59,076,859.00	156,593,350.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,076,859.00	156,593,350.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>715,477,818.00</b>	<b>875,742,138.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>715,477,818.00</b>	<b>875,742,138.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>715,477,818.00</b>	<b>875,742,138.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	715,477,818.00	875,742,138.00
221001	Их засвар	715,477,818.00	875,742,138.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(715,477,818.00)</b>	<b>(875,742,138.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	(5,611,922,191.57)	-	(5,611,922,191.57)
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(5,611,922,191.57)	-	(5,611,922,191.57)
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			(5,347,397,581.26)		(5,347,397,581.26)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(10,959,319,772.83)	-	(10,959,319,772.83)

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	11,994,722,900.00	9,270,501,850.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	10,612,526,400.00	8,394,759,712.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	9,600,351,100.00	7,526,320,312.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	929,131,700.00	917,596,373.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	929,131,700.00	917,596,373.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,671,219,400.00	6,608,723,939.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,671,219,400.00	6,608,723,939.00
212	<b>ТАТААС</b>	1,012,175,300.00	868,439,400.00
2121	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	387,233,800.00	387,233,800.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	387,233,800.00	387,233,800.00
2122	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	624,941,500.00	481,205,600.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	624,941,500.00	481,205,600.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,054,049,200.00</b>	<b>875,742,138.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,054,049,200.00	875,742,138.00
221001	Их засвар	1,054,049,200.00	875,742,138.00
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	328,147,300.00	-
230001	Эргэж төлөгдөх зээл	328,147,300.00	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	11,994,722,900.00	9,270,501,850.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	11,994,722,900.00	9,270,501,850.00
132001	Орон нутгийн төсвөөс	11,994,722,900.00	9,270,501,850.00
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар тус төсвийн гүйцэтгэл, арга хэмжээний үр дүн, сургалт, зөвлөгөөний байр, хоол болон бусад зардал, цахим дэлгүүрт байршсан барааг худалдан авах, тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг тодорхойлохтой холбоотой 4 асуудлаар зөвлөмж өгч, бүртгэл тайлагналтай холбоотой 1 алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Шүүх шинжилгээний хэлтсийн гадна авто зогсоолын 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил хэрэгжиж дууссан боловч тухайн төсөл арга хэмжээ ямар байгууллагын данс бүртгэлд тусгах нь тодорхойгүй байхад зардлаар бүртгэсэн. Энэ нь "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.4.4 дэх /Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад

эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана/ заалттай нийцэхгүй бөгөөд, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **5.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

### **1. Төсвийн гүйцэтгэл, арга хэмжээний үр дүнтэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлж буй арга хэмжээний үр дүнгийн шалгуур үзүүлэлт, суурь ба хүрэх түвшин, үр дүнг хэмжих арга, үр дүнг хэзээ тайлагнах, хэрхэн хянах талаар захирамжийн хавсралтад тусгаж батлагдахгүй байгаа нь зарцуулж буй төсвийн хөрөнгийн үр дүн, үр нөлөө тодорхой бус, үр ашиггүй болох эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 54.5.4 дэх заалттай нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлж буй арга хэмжээний үр дүнгийн шалгуур үзүүлэлт, суурь ба хүрэх түвшин, үр дүнг хэмжих арга, үр дүнг хэзээ тайлагнах, хэрхэн хянах талаар захирамжийн хавсралтад тусгуулж батлуулах, мөрийг хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлж буй арга хэмжээний үр дүн, үр нөлөөг тодорхой болгож, төсвийн үр ашгийг дээшлүүлэх.

### **2. Сургалт, зөвлөгөөний байр, хоол болон бусад зардалтай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Сургалт, зөвлөгөөн зохион байгуулах, ажлын хэсгийн хуралдаан хийх гэх мэт арга хэмжээнд оролцогч нарын байр, хоолны зардалд төсөв зарцуулж байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9.3 дахь /Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно./ заалттай нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Сургалт, зөвлөгөөн зохион байгуулах, ажлын хэсгийн хуралдаан хийх гэх мэт арга хэмжээг зохион байгуулах тохиолдолд тухайн арга хэмжээнд оролцогчид нь албан томилолтой, эсхүл сургалтын үйлчилгээний төлбөр авч байгаа бол байр, хоол, тээврийн хэрэгслийн зардлыг зохион байгуулагч тал хариуцахгүй байх.

### **3. Цахим дэлгүүрт байршсан барааг худалдан авахтай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Цахим дэлгүүрт байгаа сурагчийн ширээ сандал, компьютер гэх мэт бараа, тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалгүйгээр өөр этгээдээс худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4 дэх /Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно/ заалттай нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Төрийн сангаар ажил гүйлгээ хийхийн өмнө тухайн бараа, тоног төхөөрөмж цахим дэлгүүрт байршсан эсэхийг нягталж, цахим дэлгүүрт байршсан барааг авах, байршаагүй тохиолдолд ажил гүйлгээний төлбөрийн хүсэлтэд нотлох баримтыг хавсарган баримтжуулж хэвших.

### **4. Тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг тодорхойлохтой холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Тоног төхөөрөмжийн худалдан авалт хийх тухай бүр зах зээлийн үнийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалттай нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтын үзүүлэлтээр зах зээлийн үнийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсний үндсэн дээр тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг тодорхойлж, төлөвлөх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эргэлтийн бусад хөрөнгөд тайлагнавал зохих 20 сая төгрөгийн төсөл арга хэмжээг зардлаар тайлагнасан.	1	20,000			1	20,000	1	20,000				
Дүн	1	20,000			1	20,000	1	20,000				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Арга хэмжээний үр дүнтэй холбоотой асуудал	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Сургалт, зөвлөгөөний байр, хоол болон бусад зардалтай холбоотой асуудал	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Цахим дэлгүүрт байршсан барааг худалдан авахтай холбоотой асуудал	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг тодорхойлохтой холбоотой асуудал	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	4	-	-	-	-	-	4	-	-	-	-	-